



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/17

Цагаан-Овоо

**Сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийг  
шинэчлэн байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга:

Гишүүд:

Санхүүгийн албаны дарга

Засаг даргын орлогч

Төрийн сангийн мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын дарга

Суварга багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

2. Сумын өмч хамгаалах зөвлөл нь Төрийн байгууллагуудын үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд хяналт тавьж данснаас хасах, шилжүүлэх, актлах, устгах, үндсэн хөрөнгийн жагсаалт, элэгдэл техникийн тодорхойлолтыг үнэн зөв, бодитойгоор Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнаж улмаар аймгийн Орон нутгийн өмчийн газарт уламжилж байхыг үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сумын засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/03 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ӨЛЗИЙХИШИГ

4823010033